



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

“Тас алмааз” ХХК-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 409 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тас алмааз” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Тас алмааз” ХХК /Ш.Золбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүргэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000047